



БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Журам, байнгын комиссын
бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

1. "Барилгын салбарын оны шилдэг байгууллага, аж ахуйн нэгжийг шалгаруулах журам"-ыг 1 дүгээр, шалгаруулах байнгын комиссын бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын дагуу барилгын салбарын шилдэг байгууллага, аж ахуйн нэгжийг жил бүр шалгаруулж, нийтэд мэдээлж ажиллахыг байнгын комисс /С.Магнайсүрэн/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2011 оны 206 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Т. Мөнхбаяр

Г. МӨНХБАЯР



Барилга, хот байгуулалтын сайдын
2017 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн
13.6 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**БАРИЛГЫН САЛБАРЫН ОНЫ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА,
АЖ АХУЙН НЭГЖ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Барилга байгууламжийн шилдэг зураг төсөл боловсруулсан, шинэ дэвшилтэт материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, барилга байгууламжийг өндөр үзүүлэлттэй барьж ашиглалтад оруулсан, шинэ техник, технологи нэвтрүүлсэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчил дутагдалгүй ажиллаж, амжилт гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийн ажлын амжилтыг үнэлж урамшуулан, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд таниулан, мэдээлэхэд энэ журмын зорилго оршино.

1.2. Барилгын салбарт тусгай зөвшөөрлийн дагуу ажил, үйлчилгээ эрхэлж тухайн жилд, үр бүтээлтэй ажилласан шилдэг байгууллага, аж ахуйн нэгжийг шалгаруулж, сурталчлахад энэ журмыг мөрдөнө.

1.3. Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар томилогдсон байнгын комисс нь болзлыг хангасан байгууллага, аж ахуйн нэгжийг жил бүрийн 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор оны шилдэгт нэр дэвшиж буй аж ахуй нэгжүүдийн ажлын тайлан, үйл ажиллагааны үр дүн үзүүлэлт, мэргэжлийн хяналтын байгууллагын мэдээлэл, санал, дүгнэлтийг үндэслэн шалгаруулна.

1.4. Комисс нь болзол, шалгуур хангасан байгууллага, аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор шалгаруулна.

1.5. Оны шилдэг байгууллага, аж ахуйн нэгжийг үйл ажиллагааны дараах үндсэн чиглэлээр шалгаруулна.

- 1.5.1. барилга байгууламжийн угсралтын;
- 1.5.2. барилгын материал үйлдвэрлэлийн;
- 1.5.3. хот байгуулалтын баримт бичиг, инженер геологи, барилга байгууламжийн зураг төслийн;
- 1.5.4. өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээний;
- 1.5.5. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн.

1.6. Оны шилдэг барилга байгууламжийн угсралтын аж ахуйн нэгж байгууллагын 1 нь инженерийн шугам сүлжээ, угсралтын чиглэлийн байгууллага байна.

1.7. Энэ журамд заасан шалгуурыг хангасан байгууллага, аж ахуйн нэгжүүд тухайн оныхоо ажлын үзүүлэлтийг гаргаж жил бүрийн 8 дугаар сарын 25-ны дотор Барилгын хөгжлийн төвд битүүмжлэн хүргүүлнэ.

Хоёр. Тавигдах шаардлага, нөхцөл

2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгжийн тайлант оны ажлын үр дүн үзүүлэлтийг дараах шалгуураар дүгнэнэ. Үүнд:

2.1.1. Барилга байгууламжийн угсралтын чиглэлээр:

2.1.1.1. тухайн жилд ашиглалтад оруулсан барилга байгууламж угсралт, засварын ажлын тоо, төсөвт өртөг /сая төгрөг/, /10 хүртэл оноо/;

2.1.1.2. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жил/, /10 хүртэл оноо/;

2.1.1.3. нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлж ажилласан байдал, /5 хүртэл оноо/;

2.1.1.4. тухайн жилийн нормчлолын сангийн шимтгэл төлсөн байдал /баримт/, /10 хүртэл оноо/;

2.1.1.5. барилга байгууламжийн чанарт хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдол /Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, захиалагч байгууллагуудаас авсан тодорхойлолтыг хавсаргах/, /8 хүртэл оноо/;

2.1.1.6. ажилчдын тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг хангаж, хууль, тогтоомжийн дагуу үзүүлэх нийгмийн халамжийг хэрэгжүүлсэн байдал, зарцуулсан зардал /сая төгрөг/, /5 хүртэлх оноо/;

2.1.1.7. инженер техникийн ажилтан болон ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулсан хүний тоо, зарцуулсан зардал, /8 хүртэл оноо/;

2.1.1.8. шинэ дэвшилтэт материал, техник технологи, нэвтрүүлсэн ашигласан байдал, /8 хүртэл оноо/;

2.1.1.9. үйлдвэрлэлийн осол, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчилгүй ажилласан байдал, зарцуулсан зардал, /8 хүртэл оноо/;

2.1.1.10. байгууллагын дотоод үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцооны /ISO 9001, ISO 9012 гэх мэт/ стандартыг нэвтрүүлэх талаар дэвшил гаргасан байдал. /10 хүртэл оноо/.

2.1.2. Барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр:

2.1.2.1. тухайн жилд: /10 хүртэл оноо/;

- нийт үйлдвэрлэж борлуулсан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ;

- тохирлын гэрчилгээ авсан бүтээгдэхүүний нэр төрөл;

2.1.2.2. тухайн жилд үйлдвэрлэл, технологийн шинэчлэлд хийсэн ажил, хөрөнгө оруулалтын хэмжээ; /10 хүртэл оноо/;

2.1.2.3. нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлж ажилласан байдал; /5 хүртэл оноо/;

2.1.2.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жил/, /10 хүртэл оноо/;

2.1.2.5. ажилчдын тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг хангаж, хууль, тогтоомжийн дагуу үзүүлэх нийгмийн халамжийг хэрэгжүүлсэн байдал, зарцуулсан зардал /сая төгрөг/, /5 хүртэлх оноо/;

2.1.2.6. шинэ дэвшилтэт материал, техник технологи нэвтрүүлсэн, ашигласан байдал; /8 хүртэл оноо/;

2.1.2.7. үйлдвэрлэлийн осол, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчилгүй ажилласан байдал, зарцуулсан зардал, /8 хүртэл оноо/;

2.1.2.8. барилгын материалын чанарт хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдол /Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, захиалагч байгууллагуудаас авсан тодорхойлолтыг хавсаргах/, /8 хүртэл оноо/;

2.1.2.9. байгууллагын дотоод үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцооны /ISO 9001, ISO 9012 гэх мэт/ стандартыг нэвтрүүлэх талаар дэвшил гаргасан байдал. /10 хүртэл оноо/.

2.1.3. Хот байгуулалтын баримт бичиг, инженер геологи, барилга байгууламжийн зураг төслийн чиглэлээр:

2.1.3.1. тухайн жилд гүйцэтгэсэн хот байгуулалтын баримт бичиг, инженер геологийн зураг төслийн ажлын үнийн дүн /сая төгрөг/, /10 хүртэл оноо/

2.1.3.2. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жил/, /10 хүртэл оноо/;

2.1.3.3. нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлж ажилласан байдал; /5 хүртэл оноо/;

2.1.3.4. шинэ дэвшилтэт техник технологи, цахим тооцоолуур нэвтрүүлсэн ашигласан байдал; /8 хүртэл оноо/;

2.1.3.5. ажилчдын тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг хангаж, хууль, тогтоомжийн дагуу үзүүлэх нийгмийн халамжийг хэрэгжүүлсэн байдал, зарцуулсан зардал /сая төгрөг/, /5 хүртэлх оноо/;

2.1.3.6. инженер, техникийн ажилтан болон ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулсан хүний тоо, зарцуулсан зардал, /8 хүртэл оноо/;

2.1.3.7. зохиосон зураг төслөөс улсын экспертизээр хянагдсан тоо, илэрсэн зөрчил, дутагдал, /8 хүртэл оноо/;

2.1.3.8.байгууллагын дотоод үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцооны /ISO 9001, ISO 9012 гэх мэт/ стандартыг нэвтрүүлэх талаар дэвшил гаргасан байдал. /10 хүртэл оноо/.

2.1.4.Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээний чиглэлээр:

2.1.4.1.тухайн жилд гүйцэтгэсэн, үйлдвэрлэл, засвар, угсралтын ажлын хэмжээ, төсөвт өртөг /сая төгрөг/, /10 хүртэл оноо/;

2.1.4.2.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жил/, /10 хүртэл оноо/;

2.1.4.3.нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлж ажилласан байдал, /5 хүртэл оноо/;

2.1.4.4. угсралт засварын ажлыг хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдол /Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, захиалагч байгууллагуудаас авсан тодорхойлолтыг хавсаргах/, /8 хүртэл оноо/;

2.1.4.5.ажилчдын тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг хангаж, хууль, тогтоомжийн дагуу үзүүлэх нийгмийн халамжийг хэрэгжүүлсэн байдал, зарцуулсан зардал /сая төгрөг/, /5 хүртэл оноо/;

2.1.4.6.инженер, техникийн ажилтан болон ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулсан хүний тоо, зарцуулсан зардал, /8 хүртэл оноо/;

2.1.4.7.шинэ дэвшилтэт техник технологи, нэвтрүүлсэн ашигласан байдал, /8 хүртэл оноо/;

2.1.4.8.тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн байдал, /8 хүртэл оноо/;

2.1.4.9. үйлдвэрлэлийн осол, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчилгүй ажилласан байдал, зарцуулсан зардал. /8 хүртэл оноо/.

2.1.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр:

2.1.5.1.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жил/, /10 хүртэл оноо/;

2.1.5.2.нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлж ажилласан байдал, /5 хүртэл оноо/;

2.1.5.3.барилга байгууламжийн угсралтын үед гарсан осол, гэмтэл хэрэглэгчийн санал гомдол /байгууллагуудын энэ талын мэдээллийг шалгаруулагч байгууллага нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас албан бичгээр авна/, /8 хүртэл оноо/;

2.1.5.4.ажилчдын тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг хангаж, хууль, тогтоомжийн дагуу үзүүлэх нийгмийн халамжийг хэрэгжүүлсэн байдал, зарцуулсан зардал /сая төгрөг/, /5 хүртэл оноо/;

2.1.5.5.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан болон ажилчдын мэргэшүүлэх, чадавхжуулах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийт ажилтны сургалт, олон улсын сургалтад хамрагдсан хүний тоо, зарцуулсан зардал, /8 хүртэл оноо/;

2.1.5.6.үйлдвэрлэлийн осол, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчилгүй ажилласан байдал, зарцуулсан зардал, /8 хүртэл оноо/;

2.1.5.7.аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлтэй эсэх, /8 хүртэл оноо/;

2.1.5.8. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин, ажлын байрны нөхцөлийг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд авсан тодорхой арга хэмжээ, хүрсэн үр дүн, ахиц /Фото зураг, видео бичлэг, бусад хэлбэрээр баталгаажуулсан байх/, /8 хүртэл оноо/;

2.1.5.9.байгууллагын ажилтнуудаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал, /10 хүртэл оноо/;

2.1.5.10.байгууллагын дотоод үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцооны /ISO 9001, OHSAS 18001 гэх мэт / стандартыг нэвтрүүлэх талаар дэвшил гаргасан байдал. /10 хүртэл оноо/.

Гурав. Комиссын хуралдаан

1.1. Хуралдааны бэлтгэлийг хангах ажлыг байнгын комиссын нарийн бичгийн дарга хариуцна.

1.2. Хурлаар хэлэлцүүлэх шалгаруулалтын материалыг байнгын комиссын даргад танилцуулан хурлын товыг гаргаж гишүүдэд 2 хоногийн өмнө мэдэгдсэн байна.

1.3. Хуралд гишүүдийн 3-ны 2 нь ирснээр хүчинтэй байх бөгөөд гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй бол хуралдаан эхлэхээс өмнө мэдэгдэж өөрийн саналыг бичгээр ирүүлнэ.

1.4. Шалгаруулалтад ирүүлсэн материалд аж ахуйн нэгж бүрд гишүүн тус бүр оноо өгч, хуралд оролцсон гишүүдийн өгсөн онооны нийлбэр дүнгээр дүгнэнэ.

1.5. Шалгаруулалтын комисс нь хуралдааны тэмдэглэл, шийдвэрийг архивын тухай хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын архивт хүлээлгэн өгнө.

Дөрөв. Баталгаажуулах

4.1. Ирүүлсэн материалыг тушаалын 2 дугаар хавсралтад заасан байнгын комисс шалгаруулж дүнг Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар баталгаажуулна.

4.2. Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар баталгаажин салбарын оны шилдэг байгууллага, аж ахуйн нэгжээр шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагад барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ажлын 2 хоногийн дотор мэдэгдэнэ.

Тав. Шагнал урамшуулал

5.1. Оны шилдэг байгууллагаар шалгарсан аж ахуйн нэгжид барилга, хот байгуулалтын яамны хүндэт өргөмжлөл, туг мандуулах эрхийг жил бүрийн 9 дүгээр сарын эхний 7 хоногт болдог Барилгачдын өдөр гардуулж, аж ахуйн нэгжийн лого бүхий тугийг барилгачдын талбайд байрлуулан хүндэтгэлийн тавцанд жилийн турш мандуулна.

5.2. Шалгарсан байгууллагуудын товч танилцуулга, ажлын амжилт, туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж сурталчилна.

5.3. Барилгачдын өдрийг тэмдэглэх ажлын хүрээнд барилгын салбарын оны шилдэг байгууллага, аж ахуйн нэгжид шагнал гардуулах үйл ажиллагааг барилгачдын талбай дээр ёслол төгөлдөр зохион байгуулна.

Зургаа.Бусад

6.1. Шалгарсан байгууллага, аж ахуйн нэгж өөрийн байгууллагын онцлох тэмдэг бүхий туг /2м*1м/, гурван ширхэгийг бэлтгэж 8-р сарын 30-ны дотор Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэх.

6.4. Шалгарсан аж ахуйн нэгж байгууллага нь улирал тутам өөрийн тугийг сольж байх үүрэгтэй.

-----oOo-----